



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/911

Мандалговь

Эзэмшил газраас хамтран эзэмшигч хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалт, 31 дугаар зүйлийн 31.3 дахь заалт, мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.1.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр (Их тойруу-7-717)-т байршилтай газрыг иргэн Бат-очирын Өлзийбаяр (ЗЮ:74092813), Очирсүрэнгийн Санжаадорж (ЗЮ:94041636) нар худалдаа үйлчилгээний зориулалттай 14000м.кв (1,4 га) хамтран эзэмшдэг.Эзэмшлийн газраас Бат-Очирын Өлзийбаяр татгалзаж байгаа тул Очирсүрэнгийн Санжаадорж (ЗЮ:94041636)-д зориулалтаар 24 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/16 дугаар захирамж, мөн газар эзэмших 000051166 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4822100-57